



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 8/22

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.8, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оросын Холбооны Улсын аялал жуулчлалын зах зээлийн болон Оросын Холбооны Улсын жуулчдад визийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх боломж, шаардлагын талаарх судалгааг “Аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгааны төв” төрийн бус байгууллагаар гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Судалгааны тайланг 04 дүгээр сарын 14-ний дотор хүлээн авч холбогдох саналын хамт Соёл, спорт, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхийг Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн /Б.Халиун/-д даалгасугай.

3. Судалгааны ажлын зардал болох 4 500000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

